

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**  
/2022.11.07 - 2022.11.11/

2022.10.07

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
<b>Барилга хот байгуулалтын хэлтэс</b>		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> <li>✓ МОН3244-3245 төслийн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон.</li> <li>✓ Аймгийн барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ИТА, мэргэжилтэн ажилтын судалгааг гаргаж Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.</li> </ul>
1	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дархан сумын хэмжээнд цахилгааны өндөр хүчдэлийн агаарын шугамын хамгаалалтын зурваст орсон 233 айл өрхийн судалгаа ДСЦТС ХК -иас ирүүлсэнээс 116 айлыг зурагжуулсан.</li> <li>✓ Монсуль ХХК-ны 6кВ цахилгааны шугамын гүйцэтгэлийн зургийг мэдээллийн санд оруулсан.</li> <li>✓</li> </ul>
<b>Газрын удирдлагын хэлтэс</b>		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<ul style="list-style-type: none"> <li>➢ Дархан-уул аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгааны 41 тайлан баталгаажуулж, 12 тайлан хянаж зөвлөмжийн хамт буцаасан.</li> </ul>
3	Геодези, зураг зүйн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хаягийн зургийн дагуу 12 гараж 4 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.</li> <li>✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 10 иргэн, 1 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.</li> <li>✓ Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй”, “Эхлэх цэг хангай” ХХК-уудын хийж гүйцэтгэсэн 3-н гүйцэтгэлийн зураг, 8-н улаан шугамыг актаар шалгаж хүлээн авсан.</li> <li>✓ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны 10 сарын 26-ны өдрийн А/176 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын ГУХ-ийн дарга Г.Нямдоржын хамт Дархан-Уул аймагт геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт хийлээ. Хяналт-шинжилгээ үнэлгээг “ Гео од”, “Ёлт сүрвэй”, “Эхлэх цэг хангай” ХХК-ийг хамруулан хийж гүйцэтгэсэн.</li> <li>✓ Иргэн Ц.Гэрэлийн нэхэмжлэлтэй маргаан бүхий газар болох Дархан сумын 15 дугаар багийн 7-р хэсгийн 4 дүгээр гудамж 71,72,73 тоот газарт үзлэг хэмжилт хийлээ. ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд 15 дугаар багийн 7-р хэсэг 4 дүгээр гудамж 71 тоот газар нь иргэн И.Долгорын нэр дээр өмчлөгдөж бүртгэгдсэн байна. Харин 72,73 тоот нь ямар нэгэн иргэний нэр дээр бүртгэлгүй байгаа бөгөөд кадастрын мэдээллийн санд ажлын нэгж талбараар зурагдсан байна. Тухайн газаруудад хяналтын хэмжилт хийж үзэхэд 71 тоот газрыг өмчлөгч иргэн И.Долгорын газар руу баруун талын газар буюу 70 тоотыг өмчлөлгч Д.Эрдэнэтуяа 3.3 метр оруулж хашаагаа барьсан мөн кадастрын мэдээллийн санд эзэмшигч, өмчлөгч нь бүртгэгдээгүй 72,73 тоот газар руу зүүн талын газар буюу 74 тоот газрыг өмчлөгч Д.Энхтуяа нь хашааны урд талаар 7.7 м, хойд талаар 6.3 метр оруулж хашаагаа барьсан байна.</li> <li>✓ Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас ирсэн албан бичгийн дагуу Ашигт малтмал газрын тосны газраас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт хийх ажлын хүрээнд 243 дугаар тогтоолоор батлагдсан 6.5 сая гектар талбайн зургийг /shp file/ мэдээллийн санд оруулж усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай байгаа эсэхийг шалгалаа. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Зулзагын гол дагуу байрлах 5-н нэгж талбар Засаг даргын захирамжаар орон нутгийн хамгаалалтанд авсан хамгаалалтын бүстэй давхцаж байгааг харуулсан зургийг гаргаж хүргүүлсэн.</li> </ul>
<b>Захиргаа аж ахуйн чиглэл</b>		

1	Мэдээллийн технологи, нярав	<p><b>Мэдээлэл:</b> 70376471 нээлттэй утсаар 4, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 12 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2022-11-11-ний өдөр Цахим төвд ажиллаж Газрын цахим системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.</p> <p><b>Мэдээллийн технологи:</b> Байгууллагын цахим хуудасны Бидний тухай цэсний Байгууллагын түүхэн замнал хэсэгт шинэлэлт хийв. Байгууллагын Фэйсбүүк хуудсанд “Барилгын салбарт ажиллагсдын бүртгэл”-ийн линк, газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар хэрхэн авах тухай заавар, сумдын газрын даамлуудад газрын төлбөр, татварын мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн тухай мэдээлэл, агентлагийн нээлттэй утас 1900-0101-ийн талаар мэдээлэл, газрын тухай хууль, газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөхийг уриалсан мэдээлэл оруулав. Байгууллагын Фэйсбүүк хуудасны cover зураг, profile зургийг солив. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар хэрхэн авах тухай зааврын зургийн эхийг бэлтгэв.</p> <p><b>Нярав:</b> 10 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 5 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 12 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 7 төрлийн 21.5 ширхэг бараа материал олгов. 2022 оны 1-4-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайланг үдэж, хавтаслан хуудсуудыг дугаарлаж, архивт хүлээлгэн өгөв.</p>
---	-----------------------------	---

Тайлан боловсруулсан:

Г.Нямдорж

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж